



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.09.04 № 570

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд

заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баяндун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Л.Лхамын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч 210429700812 бүртгэлийн дугаартай Лхамдорж овогтой Лхамын Баяндун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Л.Лхамын мөрийн хөтөлбөр 7 хуудас хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч “Л.Лхам”-д

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 7 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



**ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ БОДОНГУУД ОВОГТ ЛХАМДОРЖИЙН ЛХАМЫН  
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Монгол Улсын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу "Орон нутгийн сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигч дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байна" гэсэн заалтын дагуу энэхүү мөрийн хөтөлбөрийг "Монгол Улсын тогтвортой хөгжлийн Үзэл баримтлал-30" баримт бичигтэй уялдуулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцүүлж, боловсруулав.

**НЭГ. ТОГТВОРТОЙ, ХЯНАЛТАЙ ЗАСАГЛАЛ**

**Зорилт 1.1 Хүний хөгжлийг хангаж чадах тогтвортой засаглалыг бэхжүүлнэ.**

**1.1.1 Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна:**

1. Бие даан хөгжих боломжийг бүрдүүлсэн орон нутгийн өмч, татварын боловсронгуй тогтолцоо бүхий эдийн засаг, санхүүгийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлэх чиглэлийг баримтлана.
2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, зохион байгуулалтыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулж, нийгэм, эдийн засаг, хүн амын өсөлт, байгалийн нөхцөл, нөөцийн чадавхад нийцүүлсэн, төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэх, эдийн засгийн хувьд бие даан хөгжих боломжийг хангахуйц, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарилалтад түшиглэх бодлогыг баримтлана.

**1.1.2 Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ:**

1. Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, төгөлдөржүүлэхэд идэвх санаачлагатай ажиллана.
2. Цахим бизнес, онлайн, зайн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого боловсруулалтыг дэмжинэ.

**1.1.3 Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ:**

1. Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран шатлан дэвших зарчмаар төрийн албанад ажиллах нөхцөл, баталгааг бүрэн хангасан улс төрийн, эрх зүйн, эдийн засгийн механизмыг бүрдүүлэхийг дэмжин ажиллана. Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний салшгүй чухал хэсэг болгон үнэлэх тогтолцоог дэмжинэ.

**1.1.4 Иргэний нийгэм-Хувийн хэвшил-Төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоо бүрдүүлнэ:**

1. Хүний эрхийг хамгаалахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих, хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэхийг дэмжин санаачлагатай ажиллана.

1 *Лхам*

## ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ

Сүүлийн 30 орчим жилийн хөгжлийн замналаа эргэн дүгнэвэл эдийн засгийн өсөлтөөд чиглэсэн төрийн бодлого давамгайлж, амьдралын чанар, нийгмийн баялгийн хүртээмж, тэгш байдлыг орхицуулж иржээ. Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй Дорнод хүнийг хөгжүүлэх нь хүний хөгжлийн гол зорилго болж байна.

### 2.1 Боловсрол

**Зорилт 2.1.1 Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.**

**1.1.1 Салбарын удирдлагын тогтолцоог бэхжүүлж, олон талт түншлэлийг бий болгоно:**

1. Боловсролын мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулан эрх, үүргийн оновчтой хуваарилалт хийж, олон талт түншлэлийг дэмжинэ.
2. Их дээд сургууль, MCYT, ЕБС-ийг тухайн орон нутаг, бус нутгийн хүний хөгжлийн төв болгон хөгжүүлж, бүх насны иргэд, нийгмийн салбар бүрийг хамарсан насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан тогтолцоог бэхжүүлнэ.

**1.1.2 Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулж, бүх шатны боловсролын залгамж холбоог хангаж, сургалт, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлнэ:**

1. Сургуулийн өмнөх боловсролыг бага насны хүүхдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор цэцэрлэгийн барилга, байгууламж, хүүхдийн орны тоог эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үе шаттай нэмж, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд барих, орчны стандартын дагуу хүүхэд бүрд ээлтэй, эрүүл, аюулгүй орчинг бий болгох санаачлагыг дэмжинэ.
2. Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулж, Дорнод бүсийн дээд сургуулиудад геологи, уул уурхай, эдийн засаг, бизнес, худалдаа, тээвэр, логистик, гадаад харилцаа, MCYT-үүдэд хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, барилга, аялал жуулчлал зэрэг сургалтын хөтөлбөрөөр мэргэжил олгохыг дэмжинэ.

**1.1.3 Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцийн хангана:**

1. Цэцэрлэг, ЕБС-ийн багш, туслах багшийн ажлын ачааллыг ажлын байр, хөдөлмөрийн онцлогтой уялдуулж шинэчлэх, уян хатан болгох, тэдний үйл ажиллагааг үр дүнгээр нь үнэлдэг тогтолцоотой болгож шинэчлэх, цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, бодит цалингийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэхийг дэмжинэ.

**1.1.4 Боловсролын салбарын удирдлагын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлж, хэрэглэж хэвших, нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлнэ:**

1. Нээлттэй боловсролын тогтолцоог бий болгон онлайн, зайн сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэн бүх шатны боловсролын сургалтын байгууллагыг цахим хэрэглээнд шилжүүлж, бүх насны суралцагч, иргэдэд зориулсан онлайн сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулан түгээж, албан бус боловсролын тогтолцоог хүлээн зөвшөөрөх боломжуудыг дэмжинэ.

### 2.2. Эрүүл мэнд

2 Ажил

**Зорилт 2.2.1 Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.**

**2.2.1 Иргэн, гэр бүл, ажил олгогчийн оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн /нийтийн эрүүл мэнд/ тусламж, үйлчилгээний тогтолцоог бүрдүүлнэ:**

- Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, эндэгдлийн шалтгааныг урьдчилан сэргийлэх, оношлох тогтолцоог бүрдүүлэхэд тэргүүн ээлжинд анхаарна.
- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэхийг бодлогоор дэмжинэ.

**2.2.2 Орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэхийг дэмжинэ.**

- Иргэдэд хамгийн тулгамдаж байгаа чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхитай эмнэлэг, эрүүл мэндийн төв байгуулахыг бүх талаар дэмжинэ.
- Монголын уламжлалт анааах ухааныг орчин үеийн анааах ухаантай хослуулан хөгжүүлж, экспортод гарах гарцыг дэмжин “брэнд” болгохыг бодлогоор дэмжинэ.
- Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, бүртгэл, импорт, түгээлт, цахим хяналтын тогтолцоог бий болгохыг дэмжинэ.
- Алслагдмал сум орон нутаг, хот, нийслэлд амьдарч байгаа хүмүүст үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар ижил түвшинд очиж, цахим эрүүл мэндийн системд бүрэн шилжихийг дэмжинэ.

**2.2.3 Амьдралын зөв дадал, хэвшлийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ:**

- Хүн амд эрүүл аж төрөх, амьдралын зөв дадал эзэмшүүлэх ажлыг хүүхэд наснаас нь хэвшүүлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулсан тусгай хөтөлбөр хэрэгжүүлж, дадлагын хичээл тогтмол оруулах тогтолцоог дэмжинэ.
- Аймаг, сум, баг бүрд иргэд эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, хөдөлгөөний хомсдоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал хөдөлгөөн, иог, бүжиг хийх зэрэг цогц үйлчилгээ авах боломж бүхий “Эрүүл зөв амьдрал” төвүүд ажиллуулах боломжийг төр засаг, хувийн хэвшлийн оролцоотойгоор хөгжүүлэхийг дэмжинэ.

### **2.3 Гэр бүл**

**Зорилт 2.3.1 Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ. Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоо бүрдүүлэхэд санаачлагатай ажиллана:**

- Хүн амын төрөлтийн түвшин, эргэн нөхөгдөх түвшинг дээшлүүлж, хүн амын өсөлтийг тогтвортой хангахыг бодлогоор дэмжинэ.
- Төрөөс хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, идэр, ахимаг настны талаар баримтлах салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна.
- Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжих, бодит хуримтлал бий болгоход чиглэсэн “Залуу гэр бүл” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхийг дэмжинэ.

3 *Алтан*

## 2.4. Шинжлэх ухаан, инноваци

**Зорилт 2.4.1 Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, инновацийн тогтолцоог хөгжүүлнэ.**


1. Аж ахуйн нэгж, олон нийтэд инноваци, энтерпренёршилийн боловсрол олгох, инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, шинжлэх ухаан, технологи, танин мэдэхүйн төрөл бүрийн контент бүтээх ажлыг дэмжинэ.

## 2.5 Хүнд ээлтэй амьдрах орчин, баталгаат хүнс

**Зорилт 2.5.1 Амьдралын хэрэгцээ хангасан эрүүл, ая тухтай, таатай орчин бүрдүүлж баталгаат хүнсээр хангана.**

1. Өмчлөлийн газар дээрээ аж ахуй эрхлэх, амьдрах орчноо сайжруулах, гэр хорооллын зохион байгуулалт, тохижилтыг оновчтой болгох иргэд, гэр бүлийн санаачилга, хөдөлгөөн, төслүүдийг бодлогоор дэмжинэ.
2. Генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүн, илчлэг, транс тос, чихэр, давсны агууламж өндөр хүнс, чихэрлэг ундааны импорт, үйлдвэрлэл, худалдааг татварын бодлогоор хязгаарлах талаар санаачлагатай ажиллана.
3. Үрийн сан, хөрс хамгаалалт, хөрс боловсруулалт, тариалалт, усалгаа, хураалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, жижиглэн худалдааг хамарсан хүнсний ногооны мөшгөлтийн мэдээллийн тогтолцоог бий болгон хүнсний аюулгүй байдлыг бүрэн хяналтын системийг сайжруулахыг дэмжинэ.
4. Малын бэлчээр, усалгаа, тэжээл, вакцин хэрэглээний аюулгүй байдлыг ханган үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, түүний хяналт мэдээллийн тогтолцоог бий болгохыг дэмжинэ.
5. 1-3 насны хүүхдийн хоол тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжинэ.

## 2.6 Хөдөлмөрийн зах зээл



**Зорилт 2.6.1 Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэдийг ажилтай, орлоготой болгох бодлого хэрэгжүүлнэ.**

1. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд сууринсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлэх, монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, амьдралын баталгаатай эх үүсвэрээр хангахад төр, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагааг чиглүүлнэ. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, нээлттэй боловсролын зарчимд тулгуурласан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн тэгш, хүртээмжтэй орчинг бүрдүүлнэ.

**Зорилго 2.7.1 Монгол үндэсний нэгдмэл үнэт зүйлсийг тодорхойлж, түүнийг төрөөс бодлогоор дэмжинэ.**

1. Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэхийг дэмжинэ.
2. Үндэсний монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвших чиглэлээр төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг идэвхтэй дэмжинэ.

## ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ

Үрт хугацааны хөгжлийн бодлогын үр дүнд эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхицсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хурийн талын чадавхай бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засгаа бүрдүүлж чадсан улс орон болох зорилгын хүрээнд хүч, анхаарлаа нэгтгэж ажилана. Монгол Улсын эдийн засгийн гадаад зах зээлээс хамааралтай эмзэг байдал арилж, хэрэглэгч эдийн засгаас үйлдвэрлэгч эдийн засаг руу шилжиж, Боловсруулах аж үйлдвэр (Хүнд, Хөнгөн, Хүнс), Олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийн зохимжтой харьцаа бүхий уул уурхайн аж үйлдвэр, Эрчим хүч, Тээвэр, логистикийн салбар, Аялал жуулчлал, Мэдлэгжсэн, бүтээлч эдийн засаг /Creative Industry/-аар эдийн засгийн бүтэц тодорхойлдог улс орон болох үе шаттай бодлогыг авч хэрэгжүүлнэ.

**Зорилт 3.1 Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, үр ашгийг дээшлүүлэх, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ.**

1. Эдийн засаг жил бүр тогтвортой өсөж, ажил эрхлэлт тасралтгүй нэмэгдэх боломж бий болгохыг дэмжинэ.
2. Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг баримтлана.
3. Судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг дэмжинэ.

## ДӨРӨВ. НОГООН ХӨГЖИЛ

Монгол орон байгалийн унаган төрхөө харьцангуй хэвээр хадгалж үлдсэн дэлхийн цөөн орны нэг боловч хотжилт, үйлдвэржилт зэрэг хүний хүчин зүйлийн нөлөө болон байгаль, цаг агаарын хувьсал өөрчлөлтөөс шалтгаалан байгаль орчин доройтон бохирдох, байгалийн нөөц баялаг хомстох, улмаар зарим газар нутагт экосистемийн тэнцвэр бүрэн алдагдахад хүрээд байна. Хот руу чиглэсэн их нүүдэл, хотын төлөвлөлтгүй тэлэлт, дэд бүтцийн байгууламжийн хүрэлцээгүй байдал, техник, технологийн хоцрогдол, ядуурал зэрэг олон хүчин зүйлийн нөлөөгөөр хот, суурин газрын агаар, орчин бохирдож, хүний амьдрах орчин, эрүүл мэндэд хортойгоор нөлөөлж байна.

**Зорилт 4.1 Монгол Улс дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн өөрийн орны онцлогийг харгалzan хөгжлийн замаа тодорхойлоходо байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган, үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлэн, хүний амьдралын чанарыг сайжруулах зорилгыг үндэс болгож, төрөөс бүх талын дэмжлэг үзүүлнэ.**

1. Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан, зөв зохистой ашиглах, баялгийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх бодлогыг дэмжинэ
2. Дорнод талын цагаан зээрийг хамгаалах үйл ажиллагааг идэвхжүүлэх санаачлагыг дэмжинэ
3. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандартын хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалтын иргэдийн оролцоог дэмжинэ.
4. Байгальд ээлтэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлж, хэрэглээ, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, байгалийн нөөцийг хэмнэх, хаягдалгүй эдийн засгийг /circular economy/ хөгжүүлэх бодлогыг баримтална.
5. Байгаль орчинд хор хөнөөлтэй ажиллаж байгаа уул уурхайн компаниудын эсрэг иргэний нийгмийн байгууллагууд болон нутгийн иргэдтэй хамтарч ажилана.

## ТАВ. БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

5 *Ажил*

*Дорнод Монголын талын экосистемийн унаган төрхийг хадгалж, Зүүн хойд Азийн эдийн засгийн интеграцад идэвхтэй оролцсон, ногоон технологид сууринсан хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалын зохицой хослол бүхий бус нутаг болгон хөгжүүлэх бодлогыг дэмжин ажиллана.*

**Зорилт 5.1 Бүсийн дэд бүтцийн тэнхлэгийн үндсэн сүлжээний дагуу ХАА, Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх чиглэлээр арга хэмжээнүүдийг тухайн цаг хугацаанд, холбогдох үе шатанд бодлого хууль эрх зүйн хүрээнд дэмжинэ.**

1. Малчдад мэдээлэл хүргэх тогтолцоог хөгжүүлэх, Дорнод Монголын талын эко системд зохицсон бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэхийг бодлогоор дэмжин, ногоон технологид сууринсан, экспортод чиглэсэн ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэн, бүсийн дотоод хэрэгцээг бүрэн хангах, гадаад орнууд руу экспортлох чиглэлийг дэмжинэ.
2. Тэжээлийн ургамал тариалж, малын тэжээлийн үйлдвэр байгуулах, бүсийн хэрэгцээг хангаж, бусад бүсэд нийлүүлэхийг бодлогоор дэмжинэ.
3. Газрын тос, байгалийн хийн хайгуул судалгааны ажлыг эрчимжүүлж, нөөцийг нэмэгдүүлэх төрийн бодлогыг дэмжинэ.
4. Монголын түүхэн аялал жуулчлалын төв бус болох үйл ажиллагааг бүх талаар дэмжин ажиллана. Түүх, соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлалын хүрээнд орон нутгийн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин ажиллана.

### **ЗУРГАА. НИЙГМИЙН ДУНДАЖ ДАВХАРГА**

Дундаж давхаргын хүн амын амьдралын чанарын асуудлыг өрх, гэр булийн амьжиргааны түвшин, орон сууц, хөдөлмөр эрхлэлт, аж ахуй эрхлэх сэтгэлгээ, хандлага зэрэг асуудлуудын хүрээнд авч үзэхийн зэрэгцээ дундаж давхаргын хүн амыг дэмжих санхүүгийн механизмын талаарх тусгайлсан бодлого, арга хэмжээг онцгойлон авч хэрэгжүүлэх шаардлагатай.

**Зорилт 6.1 Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүүц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийн өө тэтгэн амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ**

1. Халамжийн бодлогыг оновчтой болгож, ажил, сургалтаас ангид, идэвхгүй хэлбэрт байгаа иргэдийг нийгмийн идэвхтэй амьдралд орох, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг албан хэлбэрт орж, өсөж хөгжих эдийн засгийн боломжийг бий болгоход төр засгийн бүх шатны байгууллагын анхаарал, хамтын ажиллагааг чиглүүлэх бодлогыг баримтлана.
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гарaanы бизнесийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

### **ДОЛОО. НИЙГМИЙН АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

Улс орны амар тайван, аюулгүй байдал нь хөрш орнууд, оршин буй бус нутгийн хүрээнд хязгаарлагдахaa болж хувьсан өөрчлөгдөж буй дэлхий дахинь даяаршил, интеграцчал, аюулгүй байдлаас улам хамааралтай болсоор байна.

**Зорилт 7.1 Хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшигийн эрсдэлийг бууруулах замаар нийгмийн аюулгүй байдлыг хангана.**

6 *М.Хиц*

1. Орон нутгийн гамшигаас хамгаалах чадавхыг эрс нэмэгдүүлж, тогтолцоог бэхжүүлж, гамшигийн эрсдэлийн түвшинг бүрэн тодорхойлно. Жил бүр их хэмжээний ой, бэлчээр шатаж, эдийн засаг, байгаль экологид нөхөж баршгүй хохирол учруулдаг эрсдэлийг таслан зогсооход онцгой байдал, бусад чиглэлд шаардлагатай байгаа арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, санаачлагатай ажиллана.
2. Төр, иргэн, хувийн хэвшилийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадвар бий болгохыг дэмжинэ.

## НАЙМ. ДОРНОД АЙМАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛУУД,

### ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Дорнод аймагт тулгамдсан, иргэдээс санал болгож байгаа дараах ажлуудыг нэн тэргүүнд хийж гүйцэтгэнэ.

**Зорилт 8.1 Дорнод аймгийн иргэдээс гаргаж буй саналын дагуу холбогдох хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг хуулийн хүрээнд дэмжинэ**

1. Хотын зам засвар, өргөтгөл, арчлалтыг бие даан хийх хүчин чадалтай орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байгуулж, хотын зам засварын болон ногоон байгууламж, авто машины зогсоол, гүйлт, дугуй, явган замыг өргөжүүлэх ажлыг хариуцулахаар дэмжинэ
2. Чойбалсан хотын ТӨВ хогийн цэгийг хотын хүн амын амьдрах орчноос холдуулж, хотоос зайдуу нэгдсэн цэг бий болгох, хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, тохижилт үйлчилгээний байгууллагын хүчин чадал, санхүүжилтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах ажлыг эхлүүлэхээр дэмжиж ажиллана
3. Эрүүл мэнд, боловсролын салбарын ажилтнуудын цалин орлогыг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажил үйлчилгээний орчныг сайжруулах, шаардлагатай бусад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх, тэдний идэвх, санаачлагыг өндөржүүлж, ажилдаа амжилт гаргах боломжийг бүрдүүлэх чиглэлээр орон нутгаас санаачлага гаргаж, аймгийн төр захиргааны байгууллага, салбарын удирдлагууд, хувийн хэвшил, олон нийттэй хамтарч “Нийгмийн хөгжил” хөтөлбөрийг боловсруулна.
4. Малчин өрхүүдийг гүн өрөмийг гүний худгаар хангах ажлуудыг эхлүүлнэ.

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ

ЛХАМДОРЖ ОВОГТОЙ ЛХАМ

2024 он

Лхам